



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

“Мөнх даатгал” ХХК-д хувь нийлүүлэгчдийн  
бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн  
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мөнх даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч иргэн Р.Нямсүрэнгээс 28,220,000 /хорин найман сая хоёр зуун хорин мянга/, иргэн Т.Оюунгэрэл 90,000,000 / ерөн сая/, иргэн Ч.Жигжидээс 28,220,000 /хорин найман сая хоёр зуун хорин мянга/, иргэн Ч.Отгонжаргалаас 53,560,000 /тавин гурван сая таван зуун жаран мянга/, иргэн Д.Батжавхлангаас 550,000,000 /таван зуун тавин сая/, нийт 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Р.Нямсүрэн	282,170,000.0	28,220,000.0	310,390,000.0	11.2
2	Т.Оюунгэрэл	900,000,000.0	90,000,000.0	990,000,000.0	36.0
3	Ч.Жигжид	282,150,000.0	28,220,000.0	310,370,000.0	11.2
4	Ч.Отгонжаргал	535,680,000.0	53,560,000.0	589,240,000.0	21.4
5	Д.Батжавхлан	-	550,000,000.0	550,000,000.0	20.0
	Нийт	2,000,000,000.0	750,000,000.0	2,750,000,000.0	100.0

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000883